БАТЛАВ

НАЛУУ УХАА ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮСИЙН
ЗАХИРАГЧ Д.ОТГОНСҮРЭН

"НАЛУУ-УХАА" ЧӨЛӨӨТ БҮСИЙН ХӨГЖЛИЙН СУУРЬ СУДАЛГАА, ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр № Улаанбаатар хот

1	Үндэслэл, хэрэгцээ шаардлага	МУЗГ-ЫН 220 дугаар тогтоолоор өгсөн үүрэг даалгавар: Олон улсын тээвэр логистик, аялал жуулчлалын төрөлжсөн үйлчилгээ, аж үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг кластераар хөгжүүлэх зорилгоор Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийг байгуулна.
2	Зорилго	Эдийн засгийн тусгай бүс байгуулснаар Олон улсын тээвэр логистик, импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээг клатераар хөгжүүлэх, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах, байгаль орчинд нөлөөлж буй сөрөг нөлөөллийг багасгах, орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бүс нутгийн хөгжлийг хурдасгах зэрэг эдийн засгийн тэргүүлэх зорилт, бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.
3	Хамрах газар нутаг	Төлөвлөлтийн талбайн нийт хэмжээ-10,052.86 га
4	Шийдвэрлэх асуудлууд	Зөвлөх баг нь эдийн засгийн тусгай бүс байгуулах хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, эдийн засгийн тооцоолол, хэрэгжүүлэх цаг хугацаа ба ажиллах хүчний судалгааг хууль эрх зүйн хүрээнд оновчтой боловсруулан санал, зөвлөмж, нэгдсэн тайлан гаргана. 1. Олон улсын болон улсын, орон нутаг, хотын чанартай агаар, авто болон төмөр зам, ложистикийн нэгдсэн сүлжээтэй нягт уялдуулан төлөвлөх 2. Орон зайн төлөвлөгөө болон бүсчилсэн хөгжлийг тэтгэх хотуудын чиг үүрэг, тэдгээрийн уялдаа холбоо, газар зохион байгуулалт бүсчлэлийн төлөвлөлт 3. Тусгай бүс байгуулах тухай хууль, эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох

		4. Байгаль орчин, ногоон хөгжилд инноваци технологийг дэмжихэд чиглэсэн үр өгөөжтэй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг судлах 5. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, тогтвортой орчныг бүрдүүлэх, үр ашигтай хамтран ажиллах, олон улсын туршлагыг нутагшуулах талаар судлах 6. Төлөвлөлтийн шийдлийг үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, хөрөнгө оруулалтын тооцоог гаргаж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар санал боловсруулах
5	Баримт бичгийн бүрдэл	**Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө** 1. Төслийн ерөнхий төлөвлөгөө, стратегийн хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн санаачлага 2. Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх төслүүдийн болон ногоон хөгжлийг дэмжих төслүүдийн санаачлага 3. Тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай институт, удирдлага зохион байгуулалтын тогтолцоог оновчтой тодорхойлох санал дүгнэлтийг боловсруулах 4. Хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлэх арга зүй **Эдийн засгийн тооцоолол** 1. Налуу ухаа чөлөөт бүсийн эдийн засгийн таталцлын загварын онолын үндэс, ерөнхий хэлбэр 2. Монгол Улс болон ОУ-ын хоорондох таталцал болон түлхэлцлийн загвар 3. Улс, Бүс хоорондын эконометрик шинжилгээний үр дүн 4. Экспортлогч орны ашгийн функц болон худалдааны зардлын фүнкц 5. Хамаарлын шинжилгээний үр дүн **Хэрэгжүүлэх цаг хугацаа ба ажиллах хүчин** 1. Хөрөнгө оруулалтын цаг хугацааны төсөөлөл 2. Бүсийн хэвийн үйл ажиллагааг эрхлэн явуулах ажиллах хүчний төсөөлөл 3. Эдийн засгийн тогтвортой хөгжлийн төсөөлөл 4. ДНБ-ийн салбарын бүтцийн төсөөлөл 5. Хөрөнгө оруулалтын нийт өртгийн төсөөлөл 6. Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 7. Дижитал төлөвлөлт
6	Тайлангийн үе	1. Зөвлөх ажлын тодорхой чиглэлүүдээр явцын тайлан ирүүлэх

		2. Эцсийн тайлан ирүүлэх (Зөвлөх гарц бүтээгдэхүүн бүрийн эцсийн хувилбарыг Монгол хэлээр бэлтгэж цаасан хэлбэрээр ирүүлнэ)
7	Захиалагч	“Налуу-Ухаа Эдийн засгийн тусгай бүс”
8	Ажлын гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулагдсанаас хойш 30 хоног

БОЛОВСРУУЛСАН:
ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.НЭМЖБАДГАР